



МОНГОЛ УЛСЫН  
БОЛОВСРОЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ  
САЙДЫН ТУШААЛ

2021 оны 01 сарын 26 өдөр

Дугаар 4/23

Улаанбаатар хот

Г

Мэдээллийн ил тод байдлыг  
хангах тухай

Г

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2 дахь хэсэг, Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.9, 19 дүгээр зүйлийн 19.1 дэх заалт, Засгийн газрын Тусгай сангийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Улсын төсвийн санхүүжилтээр хэрэгжсэн, улсын нууцад хамаарахаас бусад судалгааны төсөл, эрдэм шинжилгээний ажлын тайлан, үр дүнг ил тод, нээлттэй болгох арга хэмжээг 2021 оны I улиралд багтаан зохион байгуулахыг Шинжлэх ухаан, технологийн сан /М.Тунгалаг/-д үүрэг болгосугай.
2. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж, удирдлагаар хангаж ажиллахыг Шинжлэх ухааны газар /С.Мөнхбат/, Инноваци, технологийн газар /Д.Одгэрэл/-т тус тус даалгасугай.

САЙД



Л.ЦЭДЭВСҮРЭН

142110082